# 6.2. Анги бүлгийн бүртгэл засах

Энэ үйлдлийг сургуульд үүсгэсэн байгаа ангийн мэдээллийг засахад ашиглана. Анги бүлгийн мэдээллийг засах үйлдлийг хийхэд дараах дараалльн дагуу хийнэ.

- **Анги бүлэг** үйл ажиллагааг сонгоно.




- Засах гэж буй ангийг сонгож **Үйлдэл** гэсэн товч дарна.




- Гарч ирсэн цонхонд **Бүлэг засах** үйлдэл дарснаар тухайн бүлгийн мэдээллийг засах талбар гарч ирнэ..




Анги бүлгийн мэдээлэл устгах алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

| Таб дах мэдээлэл | Тайлбар |
|---|---|
| Үндсэн мэдээлэл | Бүлгийн үндсэн мэдээллийг харуулна. Бүлгийн мэдээллийг өөрчилж хадгалсан бол засагдаж өөрчлөгдсөн хамгийн сүүлийн бүлгийн үндсэн мэдээллийг харуулна. |
| Суралцагч | Бүлэгт бүртгэлтэй суралцагчийн жагсаалтыг товч мэдээллээр хүснэгт хэлбэрээр харуулахаас гадна бүлэгт бүртгэлтэй суралцагчийг төлвөөр нь индикатораар харуулна. |
| Багш | Анги бүлэг удирдсан болон туслах багшийн мэдээллийг харуулна. Хэрэв анги удирдсан болон тухайн бүлгийн туслах багшийн мэдээллийг оруулаагүй бол бүлэг засах үйлдэл хийж анги удирдсан багшийг сонгож оруулна. |